



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/122

Номгон

「Хүн, мал, амьтны гоц халдварт тарваган тахал」
өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 11.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 11 дүгээр албан даалгавар, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2013 оны А/26 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн, мал, амьтны гоц халдварт тарваган тахал өвчний болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулахыг Зоонозын өвчин судлалын төв (С.Баасанхүү)-д;

2.Дээрх дархлаажуулалтын арга хэмжээтэй холбогдуулан Зоонозын өвчин судлалын төвөөс хуваарилсан тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг богино хугацаанд татан авч, холбогдох заавар, журмын дагуу дархлаажуулалтын ажлыг харьяа сум орон нутагтаа зохион байгуулж ажиллахыг сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарт;

3.Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад голомтот бүс нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагын нийт ажилтан, албан хаагчид, эрсдэлт бүлгийн хүн амыг бүрэн хамруулж ажиллахыг бүх шатны байгууллагын дарга, захирал, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621011059